

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 оны 03 дугаар сарын мэдээлэл

2023.03.24.

“Овоот”

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

Сумын Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2023.03.09 ний өдөр зохион байгуулж, аймаг сумын 2022 оны үйл ажиллагааны хяналт шинжилгээ-үнэлгээний дүн, цаашид анхаарах асуудал зэрэг сэдвээр зөвлөлдөж, сумын ИТХ-ын дарга сумын Засаг даргатай, сумын Засаг дарга бусад төсвийн шууд захирагч нар болон сумын Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нартай 2023 онд хамтран ажиллах гэрээг үзэглэв.

-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр

-Удирдах ажилтны зөвлөгөөний үеэр “Засгийн газар дахь хяналтын тухай хууль”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулиас тус тус мэдээлэл өгсөн.

Газар чөлөөлөх тухай хуулийн төсөлд анхаарах 10 асуудал сэдвээр сурталчилгаа хийж цахим орчинд материалыг байршууллаа. Нийт 100 гаруй иргэний хандалтыг авлаа.

-Аймгийн Шүүхийн Тамгын газраас 2 албан хаагч суманд ирж иргэдийн төлөөлөлтэй уулзалт хийж, сургалт зохион байгуулсан.

-Сумын 4 багийн төлчин, малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулж, сургалт сурталчилгааны олон талт арга хэмжээг зохион байгууллаа.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Төв,хөдөөгийн малчид иргэдийн хаваржилтын байдалд онцгойлон анхаарч малын сэг зэм устгал ариутгал, хээрийн болон ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр багуудын Засаг дарга нараар ахлуулсан ажлын хэсэг хяналт тавин ажиллаж байна. Эхний ээлжинд сумын төвийн ойролцоох үхсэн малын сэг зэм (40 толгой бод бог мал)-ийг цуглуулж, нэгдсэн хогийн цэгт байршуулахад шатахуун, хамгаалалтын бээлий хувцаст зэрэгт 300 гаруй мянган төгрөгийн зардал гарсан.

Хаврын тариалалтын төлөвлөгөө, төмс хүнсний ногооны тариалалт эрхлэгчдийн бүртгэл зэргийг цахим сайтад байршууллаа. 2023.03.22 ны байдлаар том малын зүй бус хорогдол 10588 , төл бойжилтын хувьд 2549 толгой мал төллөж, 2392 толгой мал бойжиж байна.

Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

-ЕБС-: Итали улсад төвтэй ASIA ТББ-аас хэрэгжүүлж байгаа “ОРОН НУТГААС ДЭЛХИЙ РҮҮ” төслийн хэрэгжилтийн явцын нээлттэй өдөрлөгийг багш, суралцагчид, эцэг эхчүүдийг хамруулан -"Coding study club" клубын суралцагчдын танилцуулга, бүтээлийн үзэсгэлэн -Ухаалаг дэлгэцийг сургалтад ашиглаж, сурагчдыг хөгжүүлж буй

байдал -Hours of code -сургалт, тэмцээн зэрэг үйл ажиллагааг төлөвлөн зохион байгууллаа.

Монгол ёс заншлаа өвлүүлэн уламжлах зорилтын хүрээнд: ЕБС-ийн

1-3-р ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан, 4-7-р ангийн сурагчдын дунд "Шагайн наадгай" буюу алаг мэлхий өрөх тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа.

Төрийн соёрхолт, урлагийн гавьяат зүтгэлтэн нэрт хүүхдийн зохиолч Жамбын Дашдондог агсны нэрэмжит "УРАН ЖИРГЭЭ - 2023" уран уншлагын уралдааны 1-р шатыг сумын Соёлын төв, ЕБС, Хүүхдийн цэцэрлэгээс удирдамжийн дагуу хамтран амжилттай зохион байгуулж, төрөл тус бүрд 7суралцагч тэргүүн байр шалгарч, дараагийн шатны шалгаруулалтад оролцлоо.

Сүхбаатар аймгийн боловсролын салбарын багш, сурагч, эцэг эхийн дунд зохион байгуулагдах "ОЮУН УХААНЫ VI НААДАМ"-ын нэгийн давааг багш, удирдлага, сурагч, эцэг эхчүүдийн дунд амжилттай зохион байгуулж 10 төрөлд шалгарсан 10 оролцогчид дараагийн шатны шалгаруулалтад оролцох эрхээ авлаа.

Улсын төрөлжсөн олимпиадын 2 ын давааны дэд байрт дүрслэх урлагийн багш Б. Энхмаа шалгарсан.

"Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан "ӨӨРЧЛӨЛТИЙГ ХУРДАСГАЯ уриан доор усны үнэ цэнийг судлах, усны нөөцийг зохистой ашиглах, усны бохирдлоос сэргийлэх, усыг хайрлан хамгаалах хүүхдийг байгальд ээлтэй зөв амьдралын дадал хэвшилтэй,нийгэмд үзүүлэх нөлөө агуулгын хүрээнд мэдээлэл өгч, "ДУСЛЫГ ХУРААВАЛ ДАЛАЙ ДУУЛСНЫГ ХУРААВАЛ ЭРДЭМ " хөгжөөнт тэмцээнийг 4 өртөөгөөр 7-9 дүгээр ангиудын дунд зохион байгууллаа.

Дөрөв. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

"Энэ жилдээ эрүүл жиндээ аян"-ы нээлтийн арга хэмжээг 2023 оны 03 сарын 13 өдөр зохион байгууллаа. Нээлтийн явцад

- Биеийн жингийн Индекс тодорхойлох
- Гарын авлага түгээлт
- Энэ жилдээ эрүүл жиндээ ханын самбар аянд нэгдэх
- Нээлтийн мэндчилгээ
- "Таргалалт" гэж юуг хэлэх вэ? сэдэвт сургалт
- "Түмэн дасгал "-ыг сурталчилах арга хэмжээг зохион байгуулав. Нийт 55 хүн оролцсон.

"Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг /03 сарын 24/ тохиолдуулан зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүдэд "ТИЙМ ЭЭ БИД СҮРЬЕЭГ УСТГАЖ ЧАДНА " уриатай дотоодын сургалтыг явууллаа. Сургалтын дараа :Туберкулины арьсны сорил тавих / гардан үйлдэл /-ээр, Цэр цуглуулах , тээвэрлэх /гардан үйлдэл/-ээр сургалтыг удирдаж явууллаа.

3 дугаар сард цахим орчинд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэлээр 23 мэдээллийг оруулахад 328 хандалт, 57 сэтгэгдэл, 50 хүн хуваалцсан.

Эрүүл мэндийн ажилтаны мэдлэг боловсрол , ур чадварыг сайжруулах зорилгоор аймгийн ЭМГазраас Сүхбаатар суманд зохион байгуулсан “Халдварын сэргийлэлт-2023” сургалтанд 3, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй ” сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан .

2023.03.22 нд аймгийн ЭМГ-ын холбогдох мэргэжилтэн нарыг урьж ирүүлэн Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа хандлага сэдвээр сургалт зохион байгууллаа.

Тав. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

-Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ХОГГҮЙ ХОТ АЙЛ” шалгаруулах болзолт уралдааныг 5 дахь жилдээ зохион байгуулж 358 өрхөөс 8 өрхийг сонгон шалгаруулж шагнаж урамшуулахад 4 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэлээ.

-“Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан ЕБС-ийн сурагчдын дунд АХА тэмцээн зохион байгуулж, ахлах анги болон Эко клубын сурагчдад усны үнэ цэнэ, хомсдол, усаа хэрхэн хайрлан хамгаалах, зүй зохистой хэрэглэх талаар “ӨӨРЧЛӨЛТИЙГ ХУРДАСГАЯ” сэдэвт сургалт мэдээлэлийг өглөө.

2023 оны 03 дугаар сарын 09 ны өдрийн 14 цаг 10 минутанд Сүхбаатар аймгийн Асгат Дарьганга сумын зааг Нуурт хэмээх газарт түймэр гарсан мэдээлэл ирж Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар, Асгат, Дарьганга сумдын төрийн албан хаагчид Дарьгангын БЦГ-ын мэргэжилтэн байгаль хамгаалагчид зэрэг баг бүрэлдэхүүн ажиллаж түймрийг унтраалаа.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР